



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

2023.02.25 № 02/69
танай _____ -ны № _____ -т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт онцлох ажил гүйлгээ байхгүй болно.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант онд 18 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 81 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 91.8 хувийн биелэлттэйгээр дээд шатны байгууллагадаа хүргүүлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



X. Болдбаатар Х.БОЛДБААТАР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>47258067.97</u>	<u>68188437.87</u>
33	АВЛАГА	0.00	650000.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	650000.00
34	УРЬДЧИЛГАА	19000000.00	18159000.00
34600	Урьдчилж гарсан зардал		18159000.00
34700	Бусад урьдчилгаа	19000000.00	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	19167019.42	40288389.32
351	Түүхий эд материал	9169841.42	27568479.32
35110	Тусгай зориулалттай материал	9169841.42	27568479.32
354	Хангамжийн материал	9997178.00	12719910.00
35420	Аж ахуйн материал	2813488.00	2615220.00
35470	Бусад хангамжийн материал	7183690.00	10104690.00
36	НӨӨЦИЙН БАРАА	9091048.55	9091048.55
36800	Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/	9091048.55	9091048.55
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>262862856.81</u>	<u>285468920.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	262862856.81	285468920.27
392	Биет хөрөнгө	227762856.81	250368920.27
39201	Барилга, байгууламж, орон сууц	193996634.00	193996634.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-26243921.88	-34991895.84
39203	Авто-тээврийн хэрэгсэл	63600000.00	63600000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-38866666.73	-44466666.77
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	133921638.92	181522951.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	-113335467.49	-127090692.75
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	20599674.76	24498474.76
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17155115.72	-17945966.00
39217	Ном	11246080.95	11246080.95
393	Биет бус хөрөнгө	35100000.00	35100000.00
39301	Програм хангамж	2125000.00	2125000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-2125000.00	-2125000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	35100000.00	35100000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>310120924.78</u>	<u>353657358.14</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	<u>650000.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	650000.00
413	Өглөг	0.00	650000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	650000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>310120924.78</u>	<u>353007358.14</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	310120924.78	353007358.14
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	258988494.00	258988494.00
51101	Өмч: - төрийн	258988494.00	258988494.00

512	Хуримтлагдсан үр дүн	46615979.49	89502412,85
51210	Өмнөх үеийн үр дүн	45389445.77	46615979.49
51220	Тайлант үеийн үр дүн	1226533.72	42886433,36
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	4516451.29	4516451.29
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	310120924.78	353657358.14

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2682793829.14	4984396069.75
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	86498355.14	219985299.75
120	Нийтлэг татварын бус орлого	86498355.14	219985299.75
120004	Төсөв бай ууллагын өөрийн орлого	86498355.14	219985299.75
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	86498355.14	219985299.75
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2596295474.00	4764410770.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2124390100.00	4611950500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2124390100.00	4611950500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	471905374.00	152460270.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	196202170.00	89747000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261385879.00	62713270.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2673569640.02	4939228274.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2673569640.02	4939228274.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	871936405.02	728586959.39
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	257809448.00	293805199.00
210101	Үндсэн цалин	153282252.20	184448089.00
210102	Нэмэгдэл	78374451.80	56387320.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8890976.00	34563000.00
210104	Урамшуулал	17261768.00	18406790.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	33491952.00	37096646.00
210201	Тэтгэврийн даатгал	23266221.28	25780473.81
210202	Тэтгэмжийн даатгал	2590768.78	2967530.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	2072535.03	2367304.16
210204	Ажилгүйдлийн даатгал	505747.89	577789.14
210205	Эрүүл мэндийн даатгал	5056679.02	5403548.58
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17602200.00	17857954.10
210301	Гэрэл, цахилгаан	1724363.00	1945209.10
210302	Гүлш, халаалт	13836245.00	13836345.00
210303	Цэвэр, бохир ус	2041592.00	2076400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	155029352.36	209695495.75
210401	Бичиг хэрэг	13954279.50	2858100.00
210402	Тээвэр, шатахуун	4967450.00	6852650.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	233340.00	339341.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	50622000.00	247000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9612701.40	7720218.00

210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	75639581.46	191678186.75
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25957118.00	780235.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25201765.00	430460.00
210803	Даатгалын үйлчилгээ	389300.00	294775.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	192000.00	55000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	334771034.66	151192429.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2072700.00	5340080.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	306853625.50	116958300.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	25844709.16	28894049.54
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1801633235.00	4228800314.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1658367741.00	3794206493.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	823527375.00	1456096207.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	834240366.00	2337782286.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600000.00	328000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	143265494.00	434593821.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	143265494.00	434593821.90
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	9224189.12	45167795.46
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7997655.40	2281362.10
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3721171.75	2281362.10
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7997655.40	-2281362.10
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	1226533.72	42886433.36

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2596295474.00	4764410770.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2596295474.00	4764410770.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2124390100.00	4611950500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2124390100.00	4611950500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	471905374.00	152460270.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	196202170.00	89747000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	261385879.00	62713270.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	2577295474.00	4764410770.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2577295474.00	4764410770.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	775662239.00	535610455.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	256653200.00	293382009.00
210101	Үндсэн цалин	152577454.00	184539109.00
210102	Нэмэгдэл	76761229.00	56387320.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9052976.00	34511869.00
210104	Урамшуулал	18261541.00	17943711.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34648200.00	37519836.00
210201	Тэтгэврийн даатгал	24369034.93	25787618.91

210202	Тэтгэмжийн даатгал	2600412.92	2967530.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	2080230.36	2367304.18
210204	Ажилгүйдлийн даатгал	509047.41	577789.14
210205	Эрүүл мэндийн даатгал	5089474.38	5819593.48
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17602200.00	17857954.10
210301	Гэрэл, цахилгаан	1724363.00	1945209.10
210302	Түлш, халаалт	13836245.00	13836345.00
210303	Цэвэр, бохир ус	2041592.00	2076400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	66625699.00	8772151.00
210401	Бичиг хэрэг	12272156.00	989000.00
210402	Тээвэр, шатахуун	1415750.00	2461880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	233340.00	339341.00
210404	Ном, хэвлэл	0.00	1000000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	51366700.00	471500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1337753.00	3510430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48000000.00	10000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	10000000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32156365.00	1201035.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31283865.00	685460.00
210803	Даатгалын үйлчилгээ	494000.00	294775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	202500.00	165800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176000.00	55000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	319976575.00	166877470.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	248100.00	9293000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	319728475.00	157584470.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1801633235.00	4228800314.90
2132	Бусад урсгал шилжүүлэг	1658367741.00	3794206493.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	842947375.00	1456096207.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	814820366.00	2337782286.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	600000.00	328000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	143265494.00	434593821.90
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	143265494.00	434593821.90

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,988,494.00	6,055,891.29	43,850,005.77	0.00	308,894,391.06

C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	1,539,440.00	0.00	1,539,440.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,988,494.00	6,055,891.29	45,389,445.77	0.00	310,433,831.06
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	1,539,440.00	0.00	0.00	-1,539,440.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	1,226,533.72	0.00	1,226,533.72
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	46,615,979.49	0.00	310,120,924.78
D01	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	46,615,979.49	0.00	310,120,924.78
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	46,615,979.49	0.00	310,120,924.78
D08	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	42,886,433.36	0.00	42,886,433.36
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	258,988,494.00	4,516,451.29	71,343,412.85	0.00	353,007,358.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4611950500.00	4180400478.10
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4611950500.00	4180400478.10
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	457774800.00	386193985.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	357113300.00	293382009.00
210101	Үндсэн цалин	218035300.00	184539109.00
210102	Нэмэгдэл	71422700.00	56387320.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31944000.00	34511869.00
210104	Урамшуулал	35711300.00	17943711.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	44639100.00	37519836.00
210201	Тэтгэврийн даатгал	30354600.00	25787618.91
210202	Тэтгэмжийн даатгал	3571100.00	2967530.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	2856900.00	2367304.18
210204	Ажилгүйдлийн даатгал	714200.00	577789.14
210205	Эрүүл мэндийн даатгал	7142300.00	5819593.48

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17890600.00	17857954.10
210301	Гэрэл, цахилгаан	1973700.00	1945209.10
210302	Түлш, халаалт	14397800.00	13836345.00
210303	Цэвэр, бохир ус	1519100.00	2076400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8785800.00	8772151.00
210401	Бичиг хэрэг	2305600.00	989000.00
210402	Тээвэр, шатахуун	1993400.00	2461880.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	424800.00	339341.00
210404	Ном, хэвлэл	153000.00	100000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1348700.00	471500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2560300.00	3510430.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10000000.00	10000000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10000000.00	10000000.00
2107	Томилолт, зочны зардал	100400.00	0.00
210702	Дотоод албан томилолт	100400.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1783700.00	1201035.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	756300.00	685460.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	294200.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	415100.00	294775.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	170200.00	165800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	147900.00	55000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17461900.00	17461000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9293700.00	9293000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8168200.00	8168000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4154175700.00	3794206493.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4154175700.00	3794206493.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1593746900.00	1456096207.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	2560100800.00	2337782286.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	328000.00	328000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4611950500.00	4180400478.10
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4611950500.00	4180400478.10
122005	Орон нутгийн төсвөөс	4611950500.00	4180400478.10

2.6 Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	152460270.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	152460270.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	149416470.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	149416470.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	149416470.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	3043800.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	3043800.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	152460270.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	152460270.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	89747000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	62713270.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн хүний хөгжлийн эрэлт хэрэгцээг хангах арга зүй технологийг санаачлагч, бүтээгч, түгээгч байгууллага болох алсын хараатай, Орон нутгийн боловсрол соёлын үйлчилгээний хэрэгцээг хангасан, чанартай үйлчилгээг бий болгох тасралтгүй хөгжих чадвартай мэргэшсэн мэргэжилтэн бүхий орон нутгийн хөгжлийг загварчлагч сургалт, судалгаа, арга зүйн төв байна гэж тодорхойлжээ.

Ховд аймгийн боловсрол, шинжлэх ухааны газар нь 2022 онд 20 орон тоотой ажиллаж, ерөнхий боловсролын 25 сургууль, насан туршийн боловсрол төв 2, төрийн өмчийн 33 цэцэрлэг, хувийн өмчийн 9 цэцэрлэг, мэргэжлийн боловсролын 1, их сургууль 1 нийт боловсрол, шинжлэх ухааны салбарын 71 нэгжийг хамруулан тэдгээрийг захиргааны болон мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, зөвлөн тусалж ажиллажээ.

Аймгийн засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/438 дугаар захирамжаар тус газрын бүтэц орон тоог 27 байхаар баталж, тайлант онд 20 албан хаагч, үйлчилгээний ажилтан ажилласан байна.

Дэлхий нийтийн “Тогтвортой хөгжлийн зорилтууд”-ын 4 дэх зорилго, Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024-ийг хэрэгжүүлэхийн тулд “Чанартай боловсрол” дэд хөтөлбөр хэрэгжүүлж орон нутгийн ерөнхий боловсролын чанарын үнэлгээний тогтолцоог бүрдүүлэн, сургалтын чанарыг сайжруулахаар ажиллаж байна. “Чанартай боловсрол” дэд хөтөлбөрт “Тогтвортой хөгжлийн боловсрол” дэд хөтөлбөр, “Монгол хэл бичиг”-ийн дэд хөтөлбөр, “Чадварлаг багш,

сурагч, оюутан” дэд хөтөлбөрүүд багтдаг бөгөөд эдгээр хөтөлбөрүүдийг аймгийн хэмжээнд боловсролын салбарын байгууллагууд хэрэгжүүлж байна.

Мөн дээд газраас ирүүлсэн үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн. Үүнд: Засгийн газрын 12 тогтоол, 2022 онд шинээр гарсан Боловсрол, шинжлэх ухааны сайдын 6 тушаал тэдгээртэй нийцүүлэн гаргасан 48 зөвлөмж чиглэлийг хяналтад авч хэрэгжилтийг орон нутагт зохион байгуулан ажилласнаар 96,5 хувийн биелэлттэй байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын 2022.06.03-ны А/28 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад санхүүгийн тайлан гаргахын өмнө тооцоо тооллого хийж, хяналт тавин ажилласан байна.

Боловсролын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар тайлант онд тус байгууллагад дотоод хяналт хэрэгжүүлээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Боловсрол, шинжлэх ухааны газар нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 43.5 сая төгрөгөөр буюу 14.0 хувиар өссөн байна. Үүний 18.1 сая төгрөг нь урьдчилж төлөгдсөн сургалтын зардал байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	650.0	650.0
Урьдчилгаа	19,000.0	18,159.0	(841.0)
Бараа материал	19,167.0	40,288.4	21,121.4
Үндсэн хөрөнгө	262,862.8	285,468.9	22,606.1
Нөөцийн бараа	9,091.0	9,091.0	-
Нийт хөрөнгө	310,120.8	353,657.3	43,536.5
Өр төлбөр	-	(650.0)	(650.0)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	310,120.9	354,307.3	44,186.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	310,120.9	353,657.3	43,536.4

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Тайлант онд орон нутгийн хөгжлийн сангаас барьцаа хөрөнгийн 5 хувийн үлдэгдэл 650.0 мянган төгрөгийн авлага бүртгэж, гэрээт байгууллагад өгөх 650.0 мянган төгрөгийн өглөг бүртгэгдсэн бөгөөд дараа онд барагдах боломжтой авлага, өр төлбөр байна.
- ✓ Өмнөх оны хөрөнгө бэлтгэх урьдчилж төлсөн 19,000.0 мянган төгрөгийн авлага бүртгэгдсэнийг хөрөнгөө хүлээн авч авлагыг бүрэн барагдуулсан байна. Тайлант хугацаанд хэрэгжүүлээгүй гэрээний урьдчилгаа 18159.0 мянган төгрөгийн авлагыг бүртгэж залруулсан.
- ✓ Бараа материал 21,121.4 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь яамнаас үнэ төлбөргүй тусгай зориулалтын материал хүлээж авсан дүнгээр өссөн байна.
- ✓ Тайлант онд 51500.1 мянган төгрөгийн 6 ширхэг үндсэн хөрөнгө бүртгэсний 19000.0 мянган төгрөг нь урд оны урьдчилгаа авлага, 9894.0 мянган төгрөг нь үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө байна.

3. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Ховд аймаг дахь Боловсрол шинжлэх ухааны газрын 2022 оны төсвийн төсөлд үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 4656.1 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 4611.8 сая төгрөгөөр Төсвийн төслийн саналаас 44.3 сая төгрөгөөр бууруулж 4611.8 сая төгрөгөөр баталсан нь өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлангийн хугацаанд тухайн байгууллага нь улсын төсвөөс 4,611.9 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 4180,4 сая төгрөгийн зардал санхүүжүүлж, 431.5 сая төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэн байна. Үүнээс боловсрол, шинжлэх ухааны салбарын багш ажилчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжид 4154.2 сая төгрөг төсөвлөгдсөнөөс 3794,2 сая төгрөг зарцуулсан.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Боловсрол, шинжлэх ухааны яамнаас “Боловсролын чанар шинэчлэл” төслийн дагуу 25,7 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн сангаас 89.7 сая төгрөг, боловсролын ерөнхий газраас багш нарын сургалтын зардал 36.9 сая төгрөг, нийт 152.5 сая төгрөгийн санхүүжилт авч 149.4 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж 3.0 сая төгрөгийн хэмнэлт гарган төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Боловсрол, шинжлэх ухааны газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Д.Энжаргал 2022 оны 02 дүгээр сарын 10-ноос 02 дүгээр сарын 20-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар, аудитын менежер А.Цэцэгсүрэн нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ны өдрийн 18 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 353.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 7.1 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 5.7 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2 - 15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Төрийн хэмнэлтийн хуулийн 6.2 дахь заалтыг зөрчиж хот дотор 0.6 сая төгрөгийн шатахуун зарцуулсан байна. Энэ нь элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах болон багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх зэрэг арга хэмжээнд зарцуулсан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 173 мэдээллээс хугацаандаа оруулсан 156 мэдээлэл, хугацаа хоцроосон 17 мэдээлэл биелэлт 90,1 хувьтай байна. Үүнээс хөрөнгө оруулалт, тендер худалдан авах ажиллагааны мэдээлэл 39, төсөв гүйцэтгэлтэй холбоотой 73, бусад мэдээлэл 61 мэдээлэл шилэн дансанд оруулсан.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн биелүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	1	85,8	1	85,8	100
Нийт дүн	1	85,8	4	85,8	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 18.1 сая төгрөгийн алдаа¹ илэрснээс 18.1 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд:

- ✓ Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой: Төсвийн хөрөнгөөр гэрээ байгуулсан 18.1 сая төгрөгийн гэрээт ажлын хөлсийг ажил гүйцэтгээгүй байхад шууд зардлаар бүртгэсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-т "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх" заалтыг зөрчсөн байна.

5.1 Зөвлөмж

Аудитаар нийт 0.6 сая төгрөгийн зөрчил² илэрч, зөрчлийг давтан гаргахгүй байх 0.6 сая төгрөгийн 1 зөвлөмж өглөө.

5.1.1 Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хянахад элсэлтийн ерөнхий шалгалт, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийх ажилтай холбоотойгоор хот доторх ажил үйлчилгээнд замын хуудас бичин баталгаажуулж шатахууны зардалд 0.6 сая төгрөгийн зардал санхүүжүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн хуулийн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэлт: Харилцагч байгууллагатай зардлын санхүүжилтийн тооцоог тулган баталгаажуулж, Төрийн хэмнэлтийн хуулийн 6.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
							Тоо	Дүн
Сургалтын зардал шилжүүлсэн	1.0	18,159.0	-	-			1.0	18,159.0
Дүн	1.0	18,159.0	-	-	-	-	1.0	18,159.0


Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Алдаа илрээгүй	-	-	-	-	-	-	-	-
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт хангалтгүй	1.0	677.6	-	-	-	-	1.0	677.6
Дүн	1.0	677.6	-	-	-	-	1.0	677.6
Нийт дүн	1.0	677.6	-	-	-	-	1.0	677.6

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.БОРДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР: 

Д.ЭНХЖАРГАЛ